

БИДНИЙ ЭРХЭМ ЗОРИЛГО

Даяаршлын эринд ажиллаж, амьдрах чадвартай, өндөр мэдлэгтэй мэргэжилтэн бэлтгэж, Монгол орныхоо одоо, ирээдүйн хөгжилд хувь нэмэр оруулна.

ЗОХИОМЖ ХЭВЛЭЛИЙН ЗОРИЛГО

Зохиомж дээд сургуулийн эрдэмтэн багш, эрдэм шинжилгээний ажилтанууд болон бакалавр, магистрын зэргээр өдөр болон оройн ангид сурч буй нийт оюутануудыг шаардлагатай мэдээ мэдээллээр хангах орчныг бүрдүүлэхэд оршино.

ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ



БИЗНЕСИЙН УХААНЫ ТЭНХИМИЙН ЭРХЭМ ЗОРИЛГО

Чанартай сургалт, судалгаа, үйлчилгээ бүхий хөтөлбөрөөр иргэдийн оюуны чадварыг сайжруулж нийгмийн хөгжлийг урагшлуулна.



Эрхэм оюутнууд аа,
Олон Улсын Бизнес Технологийн Зохиомж Дээд сургууль нь Монгол Улсын дээд боловсролын хурдацтай хөгжин дэвшиж дүй тэргүүний байгууллага юм.

Тус сургуульд элсэн орсон эх орны чадварлаг ирээдүй оюутан залуус та бүхний нэгэн цөийн түүхийг амжилт бүтээл, амьдралаараа дичилцэж гэгээн цүйлэт хөтлөж замыг бид халтгаа дүй болгохоор эрдмийн их өргөөндөө журан цугларлаа. Эх орон, хүн төрөлхтний хүмүүнлэг цүйлэт хувь нэмрээ оруулах, Зохиомж их сургуулийг цогцлоож зорилт бидэнд бий.

Хүн бүрдэд ажил эхлэл, ижил заяа, боломж байдаг чамьдралд олон өнгө зэрэгцэн байдаг. Хичээж, өөрийгөө дайчлан суралцаж чадаан нь эрдэм ухааныг олж авч насан туршидаа ухаанарт амьдралаа зориулах мэргэжлээ чадварлаг эзэмшдэг.

Амжилтын шигдэт түлхүүр-хичээл зүтгэл билээ. Эрхэм оюутнууд та нартаа амжилт хүсье.

Б.ЦОГТМБАЯР

Валютын ханш

	АНУ доллар	1,895.17
	Евро	2,357.69
	Японы иен	16.03
	Швейцар франк	1,960.66
	Шведийн крон	254.10
	Английн фунт	2,972.38
	ОХУ-ын рубль	38.43
	БНХАУ-н юань	308.38
	БНСУ-ын вон	1.71
	Канадын доллар	1,666.23
	Малайзын ринггит	561.37
	Туркийн лира	867.19

Татварын удирдлагын мэдээллийн TRIPS системийг ашиглалтад хүлээн авах ёслолын ажиллагаа боллоо

Дэлхийн банкны Засаглалыг дэмжих төслийн хүрээнд Татварын ерөнхий газар дээр хэрэгжсэн татварын удирдлагын мэдээллийн TRIPS системийг хүлээн авч гэрчилгээ олгох, үүнээс хойш нэг жилийн хугацаанд нийлүүлэгч тал, үнэ төлбөргүй үйлчилгээ үзүүлэх гэрээнд гарын үсэг зурах ёслолын ажиллагаа Татвар төлөгчдийн танхимд боллоо. Ийнхүү Дүү түншлэлийн баг гэрээнд заасны дагуу шинэ системийн хөгжүүлэлт, тохируулгын үе шатыг амжилттай дуусч дараагийн шатанд шилжлээ.



тэмдэглэлээ.

Татварын удирдлагын мэдээллийн TRIPS системийн гол гол туршилтын үр дүн амжилттай болсон бөгөөд туршилтын үр дүнг бататгах зорилгоор Сүхбаатар, Баянзүрх дүүрэг, Төв аймгийн татварын хэлтэст туршилт хийсэн билээ.

Шинэ системийг нээж ТЕГ-ын дарга Т.Батмагнай хэлсэн үгэндээ TRIPS систем ашиглалтад орсноор татварын мэдээллийн системийн үндсэн суурь систем болж бусад системүүдтэй холбогдох, мэдээллийн нэгдсэн сангаас мэдээлэл авах, боловсруулах, УБЕГ-гаас түргэн шуурхай мэдээлэл авах зэрэг өргөн боломж, олон давуу талтай болохыг онцлон

тэмдэглэлээ. Шинэ системийг ашиглалтад хүлээн авах ёслолын ажиллагаанд Сангийн яам, Дэлхийн Банкны Монгол дахь Суурин төлөөлөгч ноён Жеймс Андерсон, Дэлхийн банкны ахлах мэргэжилтэн ноён Захид Хаснайн, Төсөл хэрэгжилтийг дэмжих баг, Дүү түншлэлийн багийн удирдлага ажилтнууд, ТЕГ-ын удирдлагууд, нийслэл, дүүргийн татварын улсын байцаагчид оролцлоо.


Байгалийн хагас үнэт чулууг хууль бусаар хил нэвтрүүлэхийг завджээ

Эд зүйлийг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх аливаа зөрчлийг илрүүлэх зорилгоор Гаалийн байгууллага, Цагдаагийн байгууллагатай хамтран ажилласнаар тодорхой үр дүнд хүрч байна.

Тухайлбал 2014 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр Өмнөговь аймаг дахь Шивээхүрэнгийн боомтоор БНХАУ-руу гарах чиглэлд явж 15-12 ӨМА улсын дугаартай саарал өнгийн фургон маркийн тээврийн хэрэгслийг Цагдаагийн байгууллага, Гаалийн байгууллагаас хамтран саатуулж, үзлэг шалгалт хийсэн байна.

Түр саатуулсан тухайн автомашины жолооч Өмнөговь аймгийн Гурвантэс сумын иргэн Н-г байлцуулан тээврийн хэрэгсэлд нарийвчилсан үзлэг шалгалтыг хийхэд, тээврийн хэрэгслийн дотор хана таазыг зориудаар тоноглож, тухайн хэсэгтээ 125 кг улаан өнгийн байгалийн хас чулууг нуун далдалсан байсан нь илэрлээ.





ЭКСПОРТ, ИМПОРТ

ГААЛИЙН БҮРДҮҮЛЭЛТ гэж гаалийн хилээр нэвтрүүлэх барааг гаалийн байгууллагад мэдүүлсэн үеэс гаалийн бичиг баримтыг, шаардлагатай тохиолдолд барааг шалгах, ногдуулсан татварыг төлсний дараа барааг олгох, эсхүл гаалийн хилээр гаргахыг зөвшөөрөх хүртэлх цогц үйл ажиллагаа юм. Гаалийн бүрдүүлэлт нь Гаалийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, Гаалийн удирдах төв байгууллагын эрхийн актаар тогтоосон гаалийн байгууллагаас явуулах үйл ажиллагаа юм.

Экспорт, импортын гаалийн бүрдүүлэлт дараах үе шаттай явагдана:

1. Мэдүүлэх,
2. Гаалийн бичиг баримтыг шалгах,
3. Бараа, тээврийн хэрэгслийг шалгах,
4. Гаалийн болон бусад татварыг ногдуулж, барагдуулах,
5. Эзэнд нь олгох, эсхүл гаалийн хилээр нэвтрүүлэхийг зөвшөөрөх.

“Мэдүүлэх” гэдэгт гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгслийн талаархи шаардлагатай бүх мэдээллийг гаалийн мэдүүлгийн маягтын дагуу бичиж, холбогдох бичиг баримтын хамт гаалийн байгууллагад өгөхийг ойлгоно.

Бараа мэдүүлэх хэлбэр:

1. Бичгээр;
2. Мэдээллийн сүлжээгээр;
3. Зорчигч хувийн хэрэглээний эд зүйлийнхээ, мэдүүлэгч улс хоорондын шуудан илгээлтийн тухай тус тус амаар;
4. Зорчигч улаан, ногоон гарцыг сонгох буюу үйл хөдлөлөөр

ГААЛИЙН БҮРДҮҮЛЭЛТИЙН БУСАД ТӨРӨЛ:

Гаалийн түргэвчилсэн бүрдүүлэлт:

Дараахь бараанд гаалийн түргэвчилсэн бүрдүүлэлт хийнэ.

- Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас бий болсон хохирлыг арилгах зориулалтын бараа;

- цацраг идэвхт бодис, химийн хорт болон аюултай бодис, тэсэрч дэлбэрэх бодис;

- мал, амьтан;
- улс хоорондын шуудангийн илгээмж;

- сонин, тогтмол хэвлэл, мэдээллийн болон эрдэм шинжилгээ,

судалгааны материал;

- амархан муудах, гэмтэх магадлал бүхий хадгалалтын онцгой нөхцөл шаардсан бараа;

- донорын эд эрхтэн, цус, цусан бүтээгдэхүүн;

- хуульд заасан бусад бараа.

Барааг урьдчилан мэдүүлэх:

Илгээгч улсын нутаг дэвсгэрээс ачигдсан гадаадын барааг Монгол Улсын хилээр оруулахаас өмнө, эсхүл хилийн гаалийн байгууллагын хяналтаас гүний гаалийн байгууллагын хяналтад орохоос өмнө тус тус урьдчилан мэдүүлж болно. Барааны дагалдах бичиг баримтын хуулбарыг гаалийн байгууллага гаргуулан авах бөгөөд бараа ирсний дараа бичиг баримтын эх хувийг хуулбартай нь тулган шалгана.

Гаалийн хялбарчилсан бүрдүүлэлт:

Гаалийн тухай хуульд заасан бичиг баримтыг шаардахгүйгээр гаалийн мэдүүлгийн зарим хэсгийг нөхөн бичүүлэх замаар хийж, барааг гаалийн хилээр нэвтрүүлж болно.

- барааг гаалийн нутаг дэвсгэрээр дамжуулахгүйгээр хилийн чанадаас шууд гаалийн баталгаат бүсэд оруулах;

- барааг гаалийн баталгаат бүсээс гаалийн нутаг дэвсгэрээр дамжуулахгүйгээр хилийн чанадад гаргах;

Захиалгаар гаалийн бүрдүүлэлт хийх:

Мэдүүлэгч(захиалагч)-ийн гадаадад илгээх буюу хилийн чанадаас ирүүлсэн түргэн муудах, хагарч гэмтэх, ачилт, хадгалалт, тээвэрлэлтийн тусгай нөхцөл шаардагдах, улсын нууцын зэрэглэлд орох, түүнчлэн түүх соёлын дурсгалт зүйлс, валют ба валютын үнэт зүйлс, химийн бодис зэрэг бараа болон Монгол Улсын нутаг дэвсгэр дээр ажиллаж буй гадаадын дипломат төлөөлөгчийн газар болон түүнтэй адилтгах бусад байгууллагын бараа, тэнд ажиллагсдын хувийн ачаа тээшинд хийх гаалийн хяналт, бүрдүүлэлтийг захиалагчийн хүссэн газарт захиалагчийн зардлаар нь хийж болно.

ГАДААД БҮРДҮҮЛЭЛТЭД
ШААРДЛАГАТАЙ ГАДААД
ХУДАЛДААНЫ БИЧИГ БАРИМТ:

Олон улсын худалдааны бичиг баримтыг гүйцэтгэх үүргээс нь хамаарч дараахь бүлгүүдэд хуваадаг.

Авто тээврийн хэрэгслээр:

- авто тээврийн хэрэгслийн гэрчилгээ;

- ачаа тээвэрлэлтийн бичиг баримт;

- худалдааны бичиг баримт; / Гадаад худалдааны гэрээ, төлбөрийн баримт, үнийн нэхэмжлэх, баглаа боодлын жагсаалт, даатгалын бичиг баримт, техникийн бичиг баримт болон бусад барааг тодорхойлсон шаардлагатай бичиг баримтууд/

Агаарын тээврийн хэрэгслээр:

- тээврийн хэрэгслийн гэрчилгээ;

- ерөнхий мэдүүлэг;

- зорчигчийн нэрсийн жагсаалт;

- ачааны жагсаалт /карго манифест/;

- ачаа тээвэрлэлтийн бичиг баримт;

- аяллын хугацаанд хэрэглэх зорчигчийн хүнс, хэрэгслийн жагсаалт;

- худалдааны бичиг баримт;

Төмөр замаар:

- дамжуулах хуудас;

- вагон хуудас;

- тээврийн бичиг баримт;

- худалдааны бичиг баримт;

ГАДААД ХУДАЛДААНЫ БАРАА НИЙЛҮҮЛЭХ СУУРЬ НӨХЦӨЛ: /INCOTERMS/

Гадаад худалдаанд худалдах, худалдан авах гэрээ байгуулахад талуудын сонгосон ИНКОТЕРМС-ийн бараа нийлүүлэх суурь нөхцлөөс хамаарч зардал, эрсдлийг хариуцах тал тогтоогдох бөгөөд энэ нь барааны үнэ бүрдэлтэнд шууд нөлөөлнө. Иймээс гэрээ байгуулах, хэрэгжүүлэх явцад гарч болох үл ойлголцол, цаг хугацаа, хөрөнгө мөнгөний алдагдлаас сэргийлэхийн тулд олон улсын худалдааны үйл ажиллагаанд өргөн хэрэглэгддэг, нийтээр хүлээн зөвшөөрч ИНКОТЕРМС-ийн худалдааны нэр томъёог зөв ойлгож хэрэглэх шаардлагатай юм. ИНКОТЕРМС-ийг олон улсын худалдааны нэр томъёо гэж ойлгоно.

Бизнес, удирдлагын тэнхимийн 2-4 курсын оюутнуудын ангийн ажил бичих тухай

Ангийн ажил бол сургах үйл ажиллагааны явцад тухайн хичээлээр оюутны эзэмшсэн мэдлэг, ур чадвар суралцах арга барил, бие даан ажиллах чадвар зэргийг үнэлэх завсрын хяналтын нэг арга хэлбэр юм.

Эдгээр нь суралцагч хичээлийн явцад олж авсан мэдлэг, ур чадвараа ашиглан өгөгдсөн сэдвийн хүрээнд асуудал дэвшүүлж, түүнийгээ шинжлэх ухааны онол арга зүйн үүднээс боловсруулан шийдвэрлэж, бичгийн хэлээр илэрхийлэн дүгнүүлэх хэлбэрүүд билээ.

Ангийн ажил нь хэд хэдэн зорилготой.

> Тухайн хичээлээр олж авсан онолын мэдлэгийг бататгах

> Бие дааж онол практикийн тодорхой асуудлыг судлах, дүн шинжилгээ хийж, үнэлэлт дүгнэлт өгөх чадвартай болгох

> Шинжилгээ судалгааны арга технологийг эзэмших дадал чадвар олгох

> Бичиж боловсруулах ажлын ур чадварыг дээшлүүлэх

> Оюутны мэдлэг ур чадварыг нарийвчлан шалгаж, үнэн зөв үнэлгээ өгөх

Ангийн ажилд тавигдах шаардлага

* Оюутан сонгосон сэдвээ эзэмшиж, онолын зохих түвшинд асуудлаа томъёолж, шийдвэрлэхийг зорьсон байх

* Шийдвэрлэх арга замын талаар өөрийн саналыг тусгасан байх

* Холбогдох эх сурвалж болох ном, сурах бичиг, гарын авлага, сонин, хэвлэлийн материалын жагсаалтыг бичих

* Бичлэгийн хүрээнд оюутны уншиж судлах материалд хэвлэл мэдээлэл, интернат, ном сурах бичиг, эрдэм шинжилгээний тайлан, статистик тоо гэх мэт янз бүрийн хэлбэртэй байж болно.

* Дээрхийн дагуу төлөвлөгөө боловсруулна.

Төлөвлөгөө нь 2 хэсэгтэй. Үүнд

1. Төлөвлөгөө

2. Үр дүн

Төлөвлөгөөнд дараахи зүйлийг тусгана.

* Тухайн сэдвийн хүрээнд шийдвэрлэх асуудал

* Сэдвийн судлагааны объект ба судлагдахууныг тодорхойлох

* Ажлын зорилго ба зорилтыг тодорхойлох

* Шийдвэрлэх асуудлаа шинжлэх ухааны ямар онол, арга зүйгээр тайлбарлахаа тодорхойлох

* Судалгааны таамаглал дэвшүүлэх

* Судалгааны мэдээлэл авах хэлбэрээ тодорхойлох

* Мэдээллийг авах техникээ тодорхойлох

* Дүн шинжилгээ хийх аргаа тодорхойлох

Ангийн ажлын бүтэц, формат

> Удиртгал

> 3 бүлэг

> Дүгнэлт

> Ашигласан материалын жагсаалт

> Хавсралт

Удиртгал хэсэгт сэдвийн судлагдсан байдал, судлах шаардлага, шийдвэрлэх асуудал, ажлыг гүйцэтгэхэд ашигласан онол арга зүй сэдвийг судалсан дараалал зэрэг зүйлийг тусгах ба эдгээрийн тусгаж өгсөнөөр судалгааны хэсгүүд хоорондоо хэрхэн яаж холбогдож байгаа, үр дүн нь хаанаас яаж урган гарсан бэ, гэдгийг ойлгоход хялбар болно.

Нуршилгүйгээр товч тодорхой бичих шаардлагатай. Бүлгүүдэд сэдвийг судалсан байдлаа логик дэс дарааллын дагуу өгүүлдэг

Бүлгүүд гол төлөв дүгнэлт саналыг тайлбарласан шинжтэй.

Дүгнэлт ангийн ажлын чухал хэсэг бөгөөд энэ сэдвийн хүрээнд дэвшигдсэн асуудлыг хэрхэн шийдвэрлэж, ямар үр дүнд хүрсэн бэ гэдгийг тусгадаг.

Хавсралт хэсэгт тухайн сэдэвтэй холбоотой тоо баримт статистикийн гүнзгийрүүлсэн тооцоонуудыг тусгана.

Ангийн ажил бичих явцад үйлдсэн график дүрслэл, хүснэгт бүр нь тодорхой дугаартай, агуулгаа бүрэн илэрхийлж чадах тодорхой гарчиг буюу нэртэй, мөр ба баганууд нь толгойтой, график ашиглаж байгаа нөхцөлд тусгай дүрслэлүүдийг харуулсан тайлбар зүүлттэй байна.

Формат

Ariel Mon фонтын 12 үсгийн шрифтээр бичсэн А4 хэмжээний 20-ээс дээш тооны хуудастай байх үүнд хавсралт материалын хэмжээг оруулж тооцдоггүй.



Тэмцээн уралдааны тухай сонин хачин



Бизнесийн ухааны тэнхимийн Татварын хяналт шалгалт нягтлан бодох бүртгэлийн 2-р курсын оюутан Ж.Нинжмаа нь Монголын Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Институтийн дэргэдэх бүртгэл, санхүү, эдийн засгийн “Мэргэшсэн нягтлан бодогч” сониноос их дээд сургуулийн оюутнуудын дунд англи хэлний мэргэжлийн орчуулгын уралдааныг 2014 оны 10-р сарын 15-наас 2 үе шаттай зохион байгуулж амжилттай оролцож 2 шатанд шалгарсан. Уралдааны эхний шатанд МУИС-ЭЗС, СЭЗДС, ХААИС-ЭЗБС, Отгонтэнгэр ИС, Мандах бүртгэл, Зохиомж, Этүгэн ДС сургуулийн 40 гаруй оюутан эрдэм мэдлэг, ур чадвараа сорьсон бол 2-р шатанд 6 сургуулийн 18 оюутан өрсөлдсөн байна. 18 оюутны 11 оюутан нь Мандах Бүртгэл дээд сургуулийн оюутан, 3 оюутан нь ХААИС-ЭЗБС-ийн оюутан, 2 оюутан нь СЭЗДС-ын оюутан, үлдсэн - оюутан нь МУИС-ЭЗС болон Зохиомж дээд сургуулийн оюутнууд байсан юм. Орчуулгын уралдааныг ММНБИ-ийн багш, мэргэжилтнүүд шүүн явууллаа. Тэмцээний ерөнхий шүүгч, ММНБИ-ийн гадаад харилцааны хэлтсийн дарга Л.Бадамханд хэлэхдээ, шүүгчдийн зүгээс оюутнууд материалаа бүрэн орчуулсан эсэх, агуулгыг зөв гаргасан эсэх, найруулга зүй зохистой эсэх дээр 1-5 оноо өгч шүүсэн гэж байлаа.

Орчуулгын уралдаанд:

1-р байрт “Мандах бүртгэл” дээд сургуулийн Дархан салбарын оюутан Б.Мөнхбаяр,
2-р байрт СЭЗДС-ийн оюутан Э.Анарцэцэг
3-р байрт “Мандах бүртгэл” ДС-ийн оюутан Б.Хулан нар шалгарч өргөмжлөл, мөнгөн шагнал хүртлээ. Харин үлдсэн оюутнууд эн тэнцүү байсан тул тусгай байрын шагнал хүртлээ.

Татвар төлөгч иргэний баталгааны тэмдэг гэж юу вэ?

Нийслэлийн Засаг даргын 2013 оны 03 сарын 07-ны өдрийн А/170 тоот захирамжаар “Татвар төлөгч иргэний баталгааны тэмдгийн загвар”-ыг баталсан бөгөөд Нийслэлийн нутаг дэвсгэрт ажил, үйлчилгээ эрхэлж буй татвар төлөгч иргэн энэхүү загварын дагуу баталгааны тэмдгээр хангагдан ажиллаж байна. Татвар төлөгч иргэний баталгааны тэмдэг гэж юу вэ?

Татвар төлөгч иргэний баталгааны тэмдэг нь Монгол Улсад хувиараа ажил, үйлчилгээ эрхэлж буй татвар төлөгч иргэнд олгож байгаа 15*48 мм хэмжээтэй тэгш онцогт хэлбэрийн цэнхэр өнгийн дардас юм.

Баталгааны тэмдэгт:

- татвар төлөгчийн дугаар /регистрийн дугаар/,
- ургийн овог, эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр,
- баримт таних дугаар /татварын албанаас гарна/,
- цагдаагийн албанаас олгосон бүртгэлийн дугаарыг тусгасан байна.

Татвар төлөгч иргэнд баталгааны тэмдэг олгох дараалал:

Иргэн та дараах материалыг бүрдүүлэн өөрийн оршин суугаа нутаг дэвсгэрийн харъяалах татварын хэлтсийн хороо хариуцсан байцаагчид бүртгүүлэн, татвар төлөгч иргэний баталгааны тэмдэг авах захиалгыг огно. Үүнд:

1. Иргэний үнэмлэхний хуулбар
2. Тэмдгийн үнэ 20.000 төгрөг

Татварын алба татвар төлөгч иргэнийг татвар төлөгч иргэний бүртгэлийн мэдээллийн санд бүртгэж баталгааны тэмдэг олгоно.

Татвар төлөгч иргэн баталгааны тэмдэгтэй болсноор:

- Хувь хүний орлогын албан татварын тайлан /ТТ-06(А)/, татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн мэдээний маягт /ТТ-06(Б)/, жишиг татварын тайланг баталгаажуулах;
- НДШ-ийн тайланг баталгаажуулах;
- Санхүүгийн анхан шатны баримтыг баталгаажуулах;
- Банкнаас зээл авахад зээлийн гэрээг баталгаажуулах боломжтой болно.

Анхааруулга

1. Сүхбаатар дүүргийн 10,11 дүгээр хороо буюу “100 айлын” барилгын материалын захад ажил үйлчилгээ эрхэлж буй татвар төлөгч иргэнд 2010 онд баталгааны тэмдэг олгосон. Энэхүү тэмдэг нь татвар төлөгчийн ургийн овог, цагдаагийн дугаарын бичвэргүй болно. Хуучин тэмдэгтэй татвар төлөгч иргэд шинэ тэмдэг авах боломжтой.

2. Сүхбаатар дүүргийн 100 айлын барилгын материалын захаас бусад зах, худалдааны төвд ажил, үйлчилгээ эрхэлж буй татвар төлөгч иргэнд дээрх загвар бүхий тэмдгээс оор тэмдэг хэрэглэсэн тохиолдолд хуурамч тэмдэгт тооцогдох бөгөөд хуурамч тэмдэг хэрэглэсэн татвар төлөгч хуулийн дагуу хариуцлага хүлээх болно.